



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.3, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Автомат хамааралтай ажиглалтын Full Dual Channel ADS-B системийн 2 иж бүрдэл нийлүүлэх ИНЕГ/ХОӨ/ТББ/Б-11/20-33/20 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Б.Очирсүх	Холбоо, навигаци, ажиглалтын албаны дэд дарга
Гишүүд :	Д.Доржмягмар	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалт, автоматжуулалтын тасгийн ахлагч инженер
	Б.Мөнхбаяр	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Ажиглалт автоматжуулалтын хэсгийн Техник ашиглалт, автоматжуулалтын тасгийн ахлах
	Э.Энхжин	Худалдан авах ажиллагааны тасгийн хангамжийн мэргэжилтэн
	Х.Наранцацрал	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогч

2. Дээрх ажлыг гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж 2021 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээж авах комисс /Б.Очирсүх/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ